



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД
ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ БОЛОН БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН
ТАЙЛАНГ ХЯНАЖ, ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ**

АУДИТЫН КОД: ЗАА-2026/74/ШТА-НА



Улиастай хот
2026 оны

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: bat-undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Оюунсүвд
Утас: 99076038
Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn
Аудитор: Л.Гансүлд
Утас: 88161818
Цахим хаяг: gansuldl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар1

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл2

БҮЛЭГ 1. Нөхөн сонгуульд оролцсон 3 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан, аудитын хуулийн этгээдийн дүгнэлтийг хуульд заасан хугацаанаас хоцроож Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна3

1.1. Нам, эвсэл, нэр дэвшигчид хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын дансыг Төрийн аудитын байгууллагад бүртгүүлсэн байна3

1.2. Баянтэс, Идэр, Тэс сумын ИТХ-ын нөхөн сонгуульд МАН-аас нэр дэвшсэн нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлан, аудитын хуулийн этгээдийн дүгнэлтийг хуульд заасан хугацаанаас хоцроосон байна4

БҮЛЭГ 2. Нөхөн сонгуульд нэр дэвшигчид нь сонгуультай холбоотой хандив аваагүй, зардал гаргаагүй байна4

2.1. Сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчид хандив аваагүй байна4

2.2. Нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчид зардал гаргаагүй байна4

ДҮГНЭЛТ5

Товчилсон үгийн тайлбар

ТОВЧИЛСОН ҮГ	ТАЙЛБАР
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАН	Монгол ардын нам
АН	Ардчилсан нам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, МҮЕА-ын баталсан Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн гүйцэтгэсэн.

Аудитын зорилт

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Баянтэс, Идэр, Тэс сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие дааж нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн арга зүй, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитор Т.Баасанжаргал, Л.Гансүлд нар хийж гүйцэтгэлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд аймаг, сумын 4 сонгуулийн хороо, 3 хэсгийн хороо байгуулагдаж, 55 хүний бүрэлдэхүүнтэйгээр 6 хэсэгт хуваагдан ажиллажээ.

НЭГ. НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НЭР ДЭВШИГЧИД СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН, АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ДҮГНЭЛТИЙГ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНААС ХОЦРООЖ ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГАД ИРҮҮЛСЭН БАЙНА.

1.1 Нам, эвсэл, нэр дэвшигчид хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын дансыг Төрийн аудитын байгууллагад бүртгүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3¹-т заасны дагуу нөхөн сонгуульд оролцох 2 намын 6 нэр дэвшигчийн зардлын дансыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний дотор Төрийн аудитын байгууллагад бүртгүүлсэн байна.

Хүснэгт-1

Д/д	Намын нэр	Харьяалал	Банк	Дансны дугаар
1	Монгол ардын нам	Баянтэс сум	Хаан банк	5496203395
2	Монгол ардын нам	Идэр сум	Төрийн банк	170401858723
3	Монгол ардын нам	Тэс сум	Төрийн банк	171501868567
4	Ардчилсан нам	Баянтэс сум	Хаан банк	5496203248
5	Ардчилсан нам	Идэр сум	Төрийн банк	170401858718
6	Ардчилсан нам	Тэс сум	Төрийн банк	171501868566

Эх сурвалж: Аудиторын судалгаа

1.2 Баянтэс, Идэр, Тэс сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд МАН-аас нэр дэвшсэн нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлан, аудитын хуулийн этгээдийн дүгнэлтийг хуульд заасан хугацаанаас хоцроосон байна.

¹ Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3²-т заасны дагуу сумын ИТХ-ын нөхөн сонгуульд АН-аас нэр дэвшсэн 3 нэр дэвшигч зардлын тайлан, аудитын хуулийн этгээдийн дүгнэлтийг хуулийн хугацаанд ирүүлж, МАН-аас нэр дэвшсэн 3 нэр дэвшигч зардлын тайлан, аудитын хуулийн этгээдийн дүгнэлтийг хуульд заасан хугацаанаас хоцроож Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн.

Хүснэгт-2

Д/д	Намын нэр	Харьяалал	Нэр дэвшигч	Банк	Дансны дугаар
1	Монгол ардын нам	Баянтэс сум	Г.Энхсайхан	Хаан банк	5496203395
2	Монгол ардын нам	Идэр сум	М.Нархажид	Төрийн банк	170401858723
3	Монгол ардын нам	Тэс сум	Г.Баатарсүмбэр-Уул	Төрийн банк	171501868567

Эх сурвалж: Аудиторын судалгаа

ХОЁР. НӨХӨН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД НЬ СОНГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ХАНДИВААР ЭХ ҮҮСВЭР БҮРДҮҮЛЭЭГҮЙ, ЗАРДАЛ ГАРГААГҮЙ БАЙНА.

2.1 СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИД ХАНДИВ АВААГҮЙ БАЙНА.

Нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны гүйлгээ, зардлын тайлан болон холбогдох баримтуудад хийсэн аудитаар сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой хувь хүн болон хуулийн этгээдээс мөнгөн болон мөнгөн бус хандив, тусламж аваагүй болно.

Нэр дэвшигчид нь иргэн, хуулийн этгээдээс хандив аваагүй тул нийтэд мэдээлэх нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд байхгүй ажээ.

2.2 НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НЭР ДЭВШИГЧИД ЗАРДАЛ ГАРГААГҮЙ БАЙНА.

Нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа болон холбогдох үйл ажиллагаанд ямар нэгэн санхүүгийн зардал гаргаагүй, сонгуулийн зардлын дансанд гүйлгээ хийгдээгүй, сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр ямар нэгэн зардал, санхүүжилт гаргаагүй байна.

² Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

ДҮГНЭЛТ:

- ✓ Сумын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансыг Төрийн аудитын байгууллагад бүртгүүлэх үүргээ биелүүлж ажилласан байна.
- ✓ Нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлан, аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж, бүрэн ирүүлсэн байна.
- ✓ Нам, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, зардлын тайланг хуульд заасан хугацаанаас хоцорч Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар хууль, тогтоомжид тодорхой заагаагүй байна.
- ✓ Хаан банк, Төрийн банкны Завхан салбар нь АНСДИТХСТХ-ийн 56 дугаар зүйлийн 56.5³ дахь заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

³ Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.